# ХААН СОЁМБО АУДИТ ХХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/22/НА-СТА-ТЗШ**


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichko.0808@gmail.com

Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Хаан соёмбо аудит ХХК-ийн аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
3. Аудитын тайлан....10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....10
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин....10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....12
4. АУДИТЫН ТАЙЛАН....13
4.1 Ерөнхий зүйл....13
4.2 Материаллаг байдал....13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....15
5. Аудитын илрүүлэлт....15
5.2 Төлбөрийн акт....15
5.3 Албан шаардлага....15
5.4 Зөвлөмж....15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХААХҮЯ | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.20 № 01/81

танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА
Л.АРИУНАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын эзэмших эрхтэй 133,460.0 мянган төгрөгийн газрыг дүрмийн санд бүртгэлгүй байсныг залруулլаа.

**Аудитын гол асуудал**

Мал эмнэлгийн ерөнхий газар болон Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос 1,394,491.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шилжүүлэн авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 31 арга хэмжээ 87 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **244,639,319.45** | **242,837,442.87** |
| **33** | **АВЛАГА** | **30,000,000.00** | **10,000,000.00** |
| **335** | **Бусад авлага** | **30,000,000.00** | **10,000,000.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 30,000,000.00 | 10,000,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **7,200,000.00** | **00.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 7,200,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **207,439,319.45** | **232,837,442.87** |
| **351** | **Түүхий эд материал** | **150,234,073.98** | **169,013,946.40** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,166,429.25 | 1,190,429.25 |
| 35130 | Эм боох материал | 149,067,644.73 | 167,823,517.15 |
| **354** | **Хангамжийн материал** | **49,757,295.47** | **58,267,546.47** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,610,115.00 | 4,104,825.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,725,021.63 | 24,597,631.63 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,476,800.00 | 9,809,950.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,298,345.00 | 9,162,086.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 695,960.00 | 1,538,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,951,053.84 | 9,054,553.84 |
| 35600 | Мал амьтад | 7,447,950.00 | 5,555,950.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **602,205,965.48** | **560,644,378.57** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **602,205,965.48** | **560,644,378.57** |
| **392** | **Биет хөрөнгө** | **466,838,965.55** | **425,277,378.64** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 76,631,816.60 | 96,631,816.60 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -14,363,418.58 | -17,359,258.66 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 286,675,972.52 | 286,675,972.52 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -190,409,592.21 | -221,325,473.97 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 576,198,600.36 | 577,558,600.36 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -289,033,816.57 | -317,578,284.47 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,172,931.00 | 37,202,450.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,033,527.57 | -16,528,443.74 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **135,366,999.93** | **135,366,999.93** |
| 39301 | Програм хангамж | 2,280,000.00 | 2,280,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -373,000.07 | -373,000.07 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 133,460,000.00 | 133,460,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **846,845,284.93** | **803,481,821.44** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **793,524.58** | **136,153,117.16** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **793,524.58** | **136,153,117.16** |
| **413** | **Өглөг** | **793,524.58** | **136,153,117.16** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 258,874.58 | 10,424,247.16 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 43,000.00 | 410,820.00 |
| **4136** | **Бусад өглөг** | **491,650.00** | **125,318,050.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 491,650.00 | 125,318,050.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **846,051,760.35** | **667,328,704.28** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **846,051,760.35** | **667,328,704.28** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 00.00 | 133,460,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 00.00 | 133,460,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **846,051,760.35** | **533,868,704.28** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 870,068,931.27 | 712,591,760.35 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -24,017,170.92 | -178,723,056.07 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **846,845,284.93** | **803,481,821.44** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,562,862,150.99** | **3,726,902,315.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **486,212,053.99** | **1,398,692,565.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **486,212,053.99** | **1,398,692,565.50** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 486,212,053.99 | 1,398,692,565.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,002,500.00 | 171,697.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 484,209,553.99 | 1,398,520,868.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,076,650,097.00** | **2,328,209,750.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,213,809,800.00** | **1,294,699,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,213,809,800.00 | 1,294,699,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **862,840,297.00** | **1,033,510,350.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 751,287,737.00 | 648,030,700.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 65,024,080.00 | 328,782,650.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 46,528,480.00 | 56,697,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,586,879,321.91** | **3,900,046,427.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,586,879,321.91** | **3,900,046,427.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,516,565,115.15** | **3,867,709,609.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **720,641,488.56** | **694,797,872.58** |
| 210101 | Үндсэн цалин | 557,565,555.59 | 519,678,357.43 |
| 210102 | Нэмэгдэл | 139,826,832.97 | 112,305,665.83 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,249,100.00 | 30,167,855.47 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 32,645,993.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **93,335,000.00** | **88,661,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,681,700.00 | 57,013,099.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,913,000.00 | 6,905,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,530,700.00 | 9,549,700.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,382,400.00 | 1,381,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,827,200.00 | 13,811,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **24,711,135.94** | **22,244,755.60** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,825,135.94 | 3,076,257.80 |
| 210302 | Түлш, халаалт | 21,038,000.00 | 18,482,497.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 848,000.00 | 686,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **54,801,425.41** | **81,566,577.02** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,712,595.00 | 7,271,110.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,366,810.00 | 67,872,679.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,108,497.30 | 4,130,517.02 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 75,400.00 | 97,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,538,123.11 | 473,190.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 1,721,581.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **594,586,414.47** | **1,577,031,238.03** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 591,778,414.47 | 1,575,596,888.03 |
| 210502 | Хоол, хүнс | 2,808,000.00 | 1,434,350.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,906,400.00** | **1,243,360.00** |
| 210604 | Урсгал засвар | 5,906,400.00 | 1,243,360.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **27,077,300.00** | **31,540,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 27,077,300.00 | 31,540,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **855,943,429.58** | **1,293,566,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 849,277,729.58 | 1,290,561,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,200,000.00 | 752,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 548,200.00 | 504,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,300.00 | 177,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 129,900.00 | 101,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,560,000.00 | 540,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 300.00 | 929,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **139,562,521.19** | **77,057,605.91** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,838,206.95 | 10,106,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 70,724,314.24 | 66,951,105.91 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **70,314,206.76** | **32,336,817.98** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **65,986,092.00** | **23,627,520.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,000,000.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 61,914,192.00 | 22,045,520.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,071,900.00 | 1,582,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **4,328,114.76** | **8,709,297.98** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,328,114.76 | 8,709,297.98 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-24,017,170.92** | **-173,144,111.62** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **00.00** | **5,578,944.45** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 5,578,944.45 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **00.00** | **-5,578,944.45** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-24,017,170.92** | **-178,723,056.07** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **C01** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **846,051,760.35** | **846,051,760.35** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **846,051,760.35** | **846,051,760.35** |
| **C08** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **846,051,760.35** | **846,051,760.35** |
| **D01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **846,051,760.35** | **846,051,760.35** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | -133,460,000.00 | -133,460,000.00 |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **712,591,760.35** | **712,591,760.35** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 133,460,000.00 | 00.00 | 133,460,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -178,723,056.07 | -178,723,056.07 |
| **D09** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **133,460,000.00** | **533,868,704.28** | **667,328,704.28** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,078,652,597.00** | **2,328,381,447.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,002,500.00** | **171,697.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,002,500.00** | **171,697.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **2,002,500.00** | **171,697.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,002,500.00 | 171,697.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,076,650,097.00** | **2,328,209,750.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,213,809,800.00** | **1,294,699,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,213,809,800.00 | 1,294,699,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **862,840,297.00** | **1,033,510,350.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 751,287,737.00 | 648,030,700.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 65,024,080.00 | 328,782,650.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 46,528,480.00 | 56,697,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,044,614,197.00** | **2,327,021,447.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,044,614,197.00** | **2,327,021,447.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,974,299,990.24** | **2,294,384,629.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **720,037,300.00** | **684,632,500.00** |
| 210101 | Үндсэн цалин | 557,088,169.40 | 509,512,984.85 |
| 210102 | Нэмэгдэл | 139,700,030.60 | 112,305,665.83 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,249,100.00 | 30,167,855.47 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 32,645,993.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **93,335,800.00** | **88,661,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,680,700.00 | 57,013,099.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,913,800.00 | 6,905,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,531,000.00 | 9,549,700.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,382,800.00 | 1,381,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,827,500.00 | 13,811,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **24,271,135.94** | **22,684,755.60** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,825,135.94 | 3,076,257.80 |
| 210302 | Түлш, халаалт | 21,038,000.00 | 18,482,497.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 408,000.00 | 1,126,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **52,436,166.30** | **82,544,237.02** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,886,290.00 | 4,197,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,941,079.00 | 72,866,420.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,108,497.30 | 4,130,517.02 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 75,400.00 | 97,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 424,900.00 | 1,252,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **175,285,343.00** | **208,973,736.40** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 172,293,643.00 | 207,349,236.40 |
| 210502 | Хоол, хүнс | 2,814,500.00 | 1,486,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 177,200.00 | 138,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,297,300.00** | **7,099,250.00** |
| 210604 | Урсгал засвар | 7,297,300.00 | 7,099,250.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **27,077,300.00** | **31,540,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 27,077,300.00 | 31,540,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **874,559,645.00** | **1,168,248,550.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 860,693,945.00 | 1,165,243,850.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,200,000.00 | 752,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 548,200.00 | 504,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,300.00 | 177,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 129,900.00 | 101,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,760,000.00 | 540,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 300.00 | 929,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **70,314,206.76** | **32,636,817.98** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **65,986,092.00** | **23,927,520.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,000,000.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 61,914,192.00 | 22,045,520.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,071,900.00 | 1,882,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **4,328,114.76** | **8,709,297.98** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,328,114.76 | 8,709,297.98 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-34,038,400.00** | **-1,360,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,296,699,400.0 | 1,289,050,578.6 | 7,648,821.4 | 99.4 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,296,699,400.0 | 1,289,050,578.6 | 7,648,821.4 | 99.4 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,269,534,300.0 | 1,265,123,058.6 | 4,411,241.4 | 99.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 684,632,500.0 | 684,632,500.0 | 00.0 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 497,701,400.0 | 509,512,984.9 | -11,811,584.9 | 102.4 |
| 210102 | Нэмэгдэл | 117,988,600.0 | 112,305,665.8 | 5,682,934.2 | 95.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,942,500.0 | 30,167,855.5 | -3,225,355.5 | 112.0 |
| 210104 | Урамшуулал | 42,000,000.0 | 32,645,993.9 | 9,354,006.2 | 77.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,661,600.0 | 88,661,600.0 | 00.0 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,699,700.0 | 57,013,099.5 | 1,686,600.5 | 97.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,905,900.0 | 6,905,900.0 | 00.0 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,863,100.0 | 9,549,700.5 | -1,686,600.5 | 121.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,381,200.0 | 1,381,200.0 | 00.0 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,811,700.0 | 13,811,700.0 | 00.0 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,611,500.0 | 22,684,755.6 | 1,926,744.4 | 92.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,784,800.0 | 3,076,257.8 | 1,708,542.2 | 64.3 |
| 210302 | Түлш, халаалт | 18,700,100.0 | 18,482,497.8 | 217,602.2 | 98.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,126,600.0 | 1,126,000.0 | 600.0 | 99.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,051,100.0 | 24,902,017.0 | 2,149,083.0 | 92.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,197,800.0 | 4,197,800.0 | 00.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,827,700.0 | 15,224,200.0 | -396,500.0 | 102.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,593,800.0 | 4,130,517.0 | 2,463,283.0 | 62.6 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 179,800.0 | 97,500.0 | 82,300.0 | 54.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,252,000.0 | 1,252,000.0 | 00.0 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,498,900.0 | 25,452,686.0 | 46,214.0 | 99.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,360,400.0 | 25,314,186.0 | 46,214.0 | 99.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 138,500.0 | 138,500.0 | 00.0 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,860,600.0 | 7,859,800.0 | 800.0 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,360,600.0 | 1,360,000.0 | 600.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 6,500,000.0 | 6,499,800.0 | 200.0 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,920,000.0 | 5,920,000.0 | 00.0 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,920,000.0 | 5,920,000.0 | 00.0 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 405,298,100.0 | 405,009,700.0 | 288,400.0 | 99.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 402,293,400.0 | 402,005,000.0 | 288,400.0 | 99.9 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 752,100.0 | 752,100.0 | 00.0 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 504,200.0 | 504,200.0 | 00.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 177,600.0 | 177,600.0 | 00.0 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 101,600.0 | 101,600.0 | 00.0 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 540,000.0 | 540,000.0 | 00.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 929,200.0 | 929,200.0 | 00.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 27,165,100.0 | 23,927,520.0 | 3,237,580.0 | 88.1 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,165,100.0 | 23,927,520.0 | 3,237,580.0 | 88.1 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,896,800.0 | 22,045,520.0 | 1,851,280.0 | 92.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,268,300.0 | 1,882,000.0 | 1,386,300.0 | 57.6 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,296,699,400.0 | 1,289,050,578.6 | 7,648,821.4 | 99.4 |
| **1320** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,294,699,400.0 | 1,288,878,881.6 | 5,820,518.4 | 99.6 |
| 131001 | Улсын төсвөөс | 1,294,699,400.0 | 1,288,878,881.6 | 5,820,518.4 | 99.6 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,000,000.0 | 171,697.0 | 1,828,303.0 | 08.6 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.0 | 171,697.0 | 1,828,303.0 | 08.6 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,033,548,850.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,033,548,850.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,030,660,070.40** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 57,642,220.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 57,642,220.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 183,521,050.40 |

| | | |
|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 182,035,050.40 |
| 210502 | Хоол, хүнс | 1,486,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 599,450.00 |
| 210604 | Урсгал засвар | 599,450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 25,658,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,658,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 763,238,850.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 763,238,850.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,888,779.60 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 2,888,779.60 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,033,548,850.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,033,548,850.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 650,530,700.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 323,453,250.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 59,564,900.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь Аймгийн хэмжээнд мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт, халдварт, паразит болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх, оношлох болон мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлэг ариун цэврийн үзлэг шинжилгээ, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг ажил үйлчилгээг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган улмаар нийтийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн олон талт арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Тус байгууллага нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангагч, худалдааны чөлөөт байдлыг дэмжигч байгууллага болох зорилготойгоор ажиллаж байна.

Мал эмнэлгийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт 31  арга хэмжээ 87% ийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Байгууллагын дотоод хяналт хийх ажил үүргийг албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу Захиргаа, санхүүгийн албаны дарга хариуцан ажилладаг байна. Байгууллагын 2022 оны дотоод аудит, хяналт хийх төлөвлөгөөг гаргаж байгууллагын даргаар батлуулан хяналтыг хэрэгжүүлж ажиллажээ. Дотоод хяналтаар тайлант онд Улсын болон орон нутгийн хөрөнгөөр санхүүждэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсний зарцуулалтад 5 удаагийн дотоод хяналтыг түүвэр судалгааны аргаар цахим, анхан шатны баримт, бусад баримт бичигтэй тулгалт хийх чиглэлээр хийж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газарийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж тайлагнасан байна.

Тус байгууллага нь ХХААХҮ-ийн яамны сайдын тушаалаар батлагдсан "Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,363.5 мянган төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 30,000.00 | 10,000.00 | -20,000.00 |
| Бараа материал | 207,439.32 | 232,837.44 | 25,398.1 |
| Биет хөрөнгө | 466,838.97 | 425,277.38 | -41,561.6 |
| Биет бус хөрөнгө | 135,367.00 | 135,367.00 | 00.0 |
| **Нийт хөрөнгө** | 846,845.28 | 803,481.82 | -43,363.5 |
| Дансны өглөг | 793.52 | 136,153.12 | 135,359.59 |
| Хуримтлагдсан үр дүн | 846,051.76 | 533,868.70 | -312,183.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 846,845.28 | 803,481.82 | -43,363.5 |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, авлага үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөр гэсэн данс тус бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

- Цэцэрлэг сумын мал эмнэлгийн барилгыг хүлээн авч 20,000.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.
- Мал эмнэлгийн ерөнхий газраас 4,029.5 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.
- Төсвийн хөрөнгөөр 1,360.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан байна.
- Авлага дансны үлдэгдэл нь 2021 онд "Хөдөө аж ахуй хөгжлийн тулгуур" дэд хөтөлбөрийн "Монгол мал" хөтөлбөрийн хүрээнд Швейцарын хөгжлийн агентлагийн хөрөнгөөр оруулалтаар, Баянзүрх сумын мал эмнэлгийн тасгийн шинэ барилга барих 10,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг олгосон болович сумын газар

зохион байгуулалтын 2021 төлөвлөлтөд ороогүйн улмаас барилгын ажил хойшлогдож авлага үүссэнтэй холбоотой байна.

- Мал эмнэлгийн ерөнхий газараас, Биокомбинат УТҮГазар болон Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос 1,394,491.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шилжүүлэн авсан байна.
- Нийгмийн даатгалын шимтгэлд 10,424.2 мянган төгрөг, малын тарилгын өглөг 125,318.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 1,641,803.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, тооцон төлөвлөж Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 427,993.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,213,809.8 мянган төгрөгөөр батлагдаж ирсэн байна. Төсөвт 82,889.6 мянган төгрөгөөр тодотгол хийж, 1,296,699.4 мянган төгрөгөөр батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,294,699.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 171,7 мянган төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр 1,289,050.5 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 5,820.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **70801** | **Мал аж ахуйг хөгжүүлэх** | **1,001,883.20** | **1,001,787.50** | **95.70** | 100.0 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагаа | 583,033.20 | 582,959.50 | 73.7 | 100.0 |
| 82504 | Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 218,250.00 | 218,250.00 | 0 | 100.0 |
| 82507 | Малыг архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 183,600.00 | 183,600.00 | 0 | 100.0 |
| 82510 | Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлт | 17,000.00 | 16,978.00 | 22 | 99.9 |
| **70805** | **Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого** | **292,816.20** | **287,263.00** | **5,724.90** | 98.1 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагаа | 265,207.70 | 263,180.50 | 2,198.90 | 99.2 |
| 80227 | Лабораторийн итгэмжлэл | 443.4 | 155 | 288.4 | 35.0 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 27,165.10 | 23,927.50 | 3,237.60 | 88.1 |
| | **НИЙТ** | **1,294,699.40** | **1,289,050.50** | **5,820.60** | 99.6 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд :

- Мал эмнэлгийн ерөнхий газраас мал үйлчилгээний тарилгын хөлсөнд 297,412.3 мянган төгрөг
- Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос малын гоц халдварт шүлхий өвчин, бог малын цэцэг өвчин, бруцеллёзын хээлтүүлэгчийн тандалт шинжилгээний зардалд 31,370.4 мянган төгрөг
- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 500,200.0 мянган төгрөг
- Малын гоц халдварт шүлхий өвчин бог малын мялзан өвчний дэгдэлтийг хязгаарлах, хяналтайд авах зорилгоор Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 54,089.0 мянган төгрөг
- Аймгийн Засаг дарга данснаас малын вакцины тарилгад 147,830.7 мянган төгрөг
- Шинжилгээний төлбөр 2,646.5 мянган төгрөг нийт 1,033,548.9 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт санхүүжилтийн зардлыг тухай бүрт нь зохих журмын дагуу эрх нээлгэж зарцуулсан ба зарцуулаагүй үлдэгдэл 2,888.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мал эмнэлгийн газарийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитор Н.Бадамханд нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 1/14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,586,879.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 51,737.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 41,390.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэрүүдийг мэдээлээгүй Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11. зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар мэдээлнэ гэсэн заалттай, Цалингийн зардлаас дээш бусад 5 сар төгрөгөөс дээшхи 1,236,343.4 мянган төгрөгийн 29 орлогын гүйлгээ, 415,664.4 мянган төгрөгийн 32 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байгаа нь 3.2.10. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар; худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй нь гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллагад эзэмших эрхтэй газрын бүртгэл нь байгууллагын дүрмийн санд бүртгэлгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал" - ийн 5.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт:

Байгууллагын дүрмийн санд бүртгэж залруулахаар шийдвэрлэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах болон гэрээт мал эмнэлгийн нэгжүүдэд олгосон зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх тухай хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 46,500.0 | 3 | 46,500.0 | 100 |
| **Нийт дүн** | 3 | 46,500.0 | 3 | 46,500.0 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 134,820.0 мянган төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залруулсан. Үүнд:

1. Байгууллагын эзэмших эрхтэй 133,460.0 мянган төгрөгийн газрыг дүрмийн санд бүртгэлгүй байсныг залрууллаа.
2. Биет хөрөнгө худалдан авсан зардлыг мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байсныг залрууллаа.

Аудитаар нийт 136,953.1 мянган төгрөгийн зөрчил илэрч 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 10,424,247.16 төгрөг, гэрэл цахилгааны өглөг 410,820.0 төгрөг, байгууллагад төлөх өглөгт 125,318,050.0 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Батлагдсан төсвийн хязгаарт багтаан өр авлага үүсгэхгүй ажиллах

***2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Дулаан шугам гэсгээсний төлбөрийг Цэвэр бохир усны зардлаас төлсөн нь Сангийн сайдын 2019 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавартай нийцэхгүй байна.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

***3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой***

*3.1. <u>Илрүүлэлт:</u>*

Төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэрүүдийг мэдээлээгүй Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11. зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар мэдээлнэ гэсэн заалттай, Цалингийн зардлаас дээш бусад 5 сар төгрөгөөс дээшхи 1,236,343.4 мянган төгрөгийн 29 орлогын гүйлгээ, 415,664.4 мянган төгрөгийн 32 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байгаа нь 3.2.10. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ

журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар; худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй нь гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

3.2. ***Өгсөн зөвлөмж:***

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Газар эзэмших эрхийг дүрмийн санд бүртгэсэн | 1 | 133,460.0 | | | 1 | 133,460.0 | 1 | 133,460.0 | | |
| Хөрөнгө худалдан авсан зардлыг буруу тайлагнасан | 1 | 1,360.0 | | | 1 | 1,360.0 | 1 | 1,360.0 | | |
| **Дүн** | **1** | **134,820.0** | | | **1** | **134,820.0** | **1** | **134,820.0** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн | 1 | 800.0 | | | | | 1 | 800.0 | | | | |
| Өр авлага үүсгэсэн | 1 | 136,153.1 | | | | | 1 | 136,153.1 | | | | |
| Дүн | 2 | 136,953.1 | | | | | 2 | 136,953.1 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээллийг мэдээлээгүй | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |

| Нийт дүн | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
|---|---|---|---|---|---|---|---|---|

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Х.ДИЙМАА

АУДИТОР Н.БАДАМХАНД

УЛААНБААТАР ХОТ
ХААН СОЁМБО АУДИТ ХХК
ШТК0364 6697798
9021091402